Агуулга

Нэгдүгээр хэсэг. Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлууд.....1-6

Хоёрдугаар хэсэг: Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, албан бичгийн эргэлтэд хяналт тавих ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажлууд.....6

Гуравдугаар хэсэг: Байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажлууд.....6-7
3.1 Хүний нөөцийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил.....6
3.2 Эдийн засгийн баталгааг хангах ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажил.....6
3.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, аятай нөхцөлөөр хангах ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажил.....6-7
3.4 Орон сууцны нөхцөлөө сайжруулах, орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажил.....7
3.5 Албан хаагчдын ажлын орчин нөхцөлийг сайжруулж, тэдний эрүүл мэндийг хамгаалах ажлын хүртээмж, чанарыг дээшлүүлэх ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажил.....7

Дөрөвдүгээр хэсэг. Байгууллагын төсөв, санхүүгийн чиглэлээр.....8-9

Тавдугаар хэсэг. Байгууллагын үйл ажиллагаатай холбогдох бүх төрлийн мэдээллийг олон нийтэд ил тод, ойлгомжтой байдлаар түгээх.....9-10

Зургаадугаар хэсэг: Эрх зүйн мэдээ мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр зохион байгуулж, гүйцэтгэсэн ажлууд.....10-13
6.1 Сургалт, сурталчилгааны чиглэлээр гүйцэтгэсэн ажлууд.....10-11
6.2 Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр.....11-12
6.3 Байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах чиглэлээр гүйцэтгэсэн ажлууд.....12-13

Долоодугаар хэсэг. Бусад ажлууд.....13-14

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр:

Хууль зүйн туслалцааны төвийн нийт салбарын улсын өмгөөлөгчид нь 2019 оны жилийн эцсийн байдлаар 2957 эрүүгийн хэргийн 3178 холбогдогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлснээс 1847 хэргийг шүүхээр, 139 хэргийг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлж, төлбөрийн чадвартай болох нь тогтоогдсон 247, харьяаллын биш 64, өмгөөлөгчөөс татгалзсан 14, бусад шалтгаанаар 76 нийт 401 хэргийн холбогдогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж, 570 хэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа явж байна.

Хууль зүйн туслалцаа үзүүлэхээр буюу өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээр хүлээн авсан нийт 2957 эрүүгийн хэргийн 3178 холбогдогчоос:

- Насанд хүрээгүй 311
- Бичиг үсэг тайлагдаагүй 549
- Хөгжлийн бэрхшээлтэй 132
- Гадаадын иргэн 11
- Оршин суух тодорхой хаяггүй Монгол Улсын 35 иргэн тус тус үйлчлүүлсэн байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар хүлээн авсан хэрэг, холбогдогчийн тоон мэдээллийг 2018 оны энэ үеийн тоон мэдээлэлтэй харьцуулан харуулбал:



	2018 он	2019 он
Хэрэг	2781	2957
Холбогдогч	3003	3178

2019 оны жилийн эцсийн байдлаар өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээр хүлээн авсан нийт хэрэг, холбогдогчийн тоон мэдээллийг 2018 оны энэ үеийн тоон мэдээлэлтэй харьцуулахад хэрэг 176 буюу 6.3 хувиар, холбогдогч 175 буюу 5.8 хувиар өссөн үзүүлэлт харагдаж байна.

Тайлант хугацаанд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээр хүлээн авсан нийт хэрэг болон холбогдогчийн тоон мэдээллийг салбар тус бүрээр танилцуулбал:

/Ихээс бага руу эрэмбэлсэн байдлаар/

№	Салбар	Хүлээн авсан эрүүгийн хэргийн тоо	Эрүүгийн хэргийн холбогдогч
1	Баянзүрх дүүрэг	387	408
2	Сонгинохайрхан дүүрэг	296	320
3	Сүхбаатар дүүрэг	211	214
4	Хан-Уул дүүрэг	202	213
5	Баянгол дүүрэг	199	202
6	Чингэлтэй дүүрэг	186	189
7	Төв аймаг	142	166
8	Дархан-Уул аймаг	102	126
9	Дорнод аймаг	118	121
10	Налайх дүүрэг	107	107
11	Хөвсгөл аймаг	102	106
12	Баянхонгор аймаг	94	94
13	Булган аймаг	81	89
14	Архангай аймаг	79	86
15	Өвөрхангай аймаг	54	69
16	Сүхбаатар аймаг	67	68
17	Сэлэнгэ аймаг	54	63
18	Сэлэнгэ аймаг /Мандал сум/	52	60
19	Орхон аймаг	58	58
20	Дундговь аймаг	48	56
21	Увс аймаг	46	56
22	Багануур дүүрэг	39	53
23	Баян-Өлгий аймаг	43	51
24	Хэнтий аймаг	34	38
25	Говьсүмбэр аймаг	32	34
26	Ховд аймаг	25	30
27	Говь-Алтай аймаг	29	29
28	Дорноговь аймгийн /Замын-Үүд сум/	21	23
29	Завхан аймаг	19	19
30	Дорноговь аймаг	19	19

31	Өмнөговь аймаг	11	11
Нийт		**2957**	**3178**

Тайлант хугацаанд улсын өмгөөлөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аль шатнаас оролцож эхэлсэн эсэх тоон үзүүлэлтийг танилцуулбал:

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шат	Хэргийн тоо
Хэрэг бүртгэх шат	246
Мөрдөн байцаах шат	1607
Прокурорын шат	154
Анхан шатны шүүх	911
Давж заалдах шатны шүүх	36
Хяналтын шатны шүүх	3

Дээр дурдсан тоон үзүүлэлтээс үзэхэд нийт 2957 эрүүгийн хэргийн 1853 буюу 62.6 хувьд нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатнаас эхлэн өмгөөллийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа нь харагдаж байна. Энэ нь төлбөрийн чадваргүй эрүүгийн хэргийн холбогдогчдод эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний үе шатнаас цаг алдалгүй хууль зүйн туслалцааг үзүүлж, иргэний хуулиар олгогдсон эрхийг төрөөс хангаж ажилласан байна гэсэн үг юм.

Улсын өмгөөлөгчдийн шүүхийн өмнөх шатанд болон шүүхээр шийдвэрлүүлсэн нийт 1986 хэргийг гэмт хэргийн ангиллаар нь танилцуулбал:

- 1110 буюу 56 хувийг хөнгөн гэмт хэрэг
- 876 буюу үлдсэн 44 хувийг хүнд гэмт хэрэг тус тус эзэлж байна.



2019 оны жилийн эцсийн байдлаар шүүхийн өмнөх шатанд болон шүүхээр шийдвэрлүүлсэн нийт 1986 хэрэгт улсын өмгөөлөгчид доорх хугацаагаар тухайн хэрэгт оролцож хууль зүйн туслалцаа үзүүлсэн байна:

- 532 хэрэгт 14 хоног хүртэл;
- 988 хэрэгт 15-90 хоног хүртэл;
- 305 хэрэгт 91-150 хоног хүртэл;

- 161 хэрэгт 151 хоногоос дээш хугацаагаар тус тус оролцсон байна.



Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд зарцуулж буй хугацааг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулан харахад Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчид нийт шийдвэрлэгдсэн хэргийн дийлэнх хувийг 15-90 хоногт буюу хуулийн хугацаанд нь хэргийг шийдвэрлүүлэн ажиллаж байгаа нь харагдаж байна.

Тайлант хугацаанд Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчдийн шүүхийн болон шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлсэн нийт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл:

- Хулгайлах 811 буюу 41%;
- Хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол санаатай учруулах 572 буюу 29%;
- Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 7 буюу 0,3%;
- Дээрэмдэх 99 буюу 5%;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих 85 буюу 4.2%;
- Хүнийг алах 47 буюу 2.3%;
- Бусад гэмт хэрэг 365 буюу 18.5%-ийг тус тус эзэлж байна.

Үзүүлэлтээс харахад үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдийн 46 хувь нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон байгаа нь улсын өмгөөлөгчид хандаж байгаа иргэд нэг талаас амьжиргааны түвшин доогуур, эрхэлсэн тодорхой ажилгүй, тогтмол орлогогүй, зав чөлөө ихтэй, нөгөө талаас боловсролын түвшин доогуур, хуулийн мэдлэг багатайгаас өөрийн үйлдлийн учир холбогдол, хариуцлагыг ухамсарлах чадвар сул байгаатай шууд хамааралтай байна.

Хууль зүйн туслалцааны төв нь 2019 оны 12 дугаар сарын байдлаар эрэгтэй 10134, эмэгтэй 4841 иргэн буюу нийт 14975 иргэнд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгсөнөөс гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 451 иргэнд хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хүрээнд БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр зорчих гэж буй иргэдэд 27

удаагийн сургалт явуулж 880 иргэнд хууль эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан байна.

Хоёр. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, албан бичгийн эргэлтэд хяналт тавих ажлын хүрээнд:

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль болон “Хууль зүйн туслалцааны төвд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын хүрээнд иргэдээс гаргаж буй өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар хууль зүйн туслалцаа хүссэн өргөдөл 3178, хүний нөөцийн асуудлаар /ажилд орох, ажлаас чөлөөлүүлэх тухай/ 16, харьяаллын бус асуудлаар хандсан 9, улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн гомдол 9, албан хаагчдаас ирүүлсэн санал хүсэлт 31, бусад асуудлаар 24 өргөдөл гомдол ирсэн бөгөөд нийт 3267 өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн.

Шийдвэрлэлтийн хуулийн хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй байна.

Хуулийн хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй бөгөөд ажлын албанд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 142 албан бичиг ирсэнээс шууд буюу хариугүй 57 албан бичиг, хариутай 85 албан бичиг ирж холбогдох хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Мөн төвийн хүний нөөцтэй холбогдох 29 тушаал, байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбогдох 23 тушаал гарсан байна.

Хууль зүйн туслалцааны төвийн 2019 оны 1-р улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2019 оны 03 дүгээр сарын 28-ны өдрийн 2/102, 2-р улирлын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 2/196, 3-р улирлын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 1/243, 4-р улирлын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1/337 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн байна.

Гурав. Байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

3.1 Хүний нөөцийн чиглэлээр:

Тайлант хугацаанд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу legalinfo.mn, Монголын Хуульчдын холбоо ТББ-ын масс цахим шуудан болон Хууль зүйн туслалцааны төвийн албан ёсны цахим хуудсанд улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтын зарыг 9 удаа байршуулан нийтэд мэдээлсэн. 2019 онд Хууль зүйн туслалцааны төвийн салбарын улсын өмгөөлөгчдийн сул орон тоо /давхардсан тоогоор/ гарсан /Сэлэнгэ аймаг,

Өвөрхангай аймаг, Булган аймаг, Сонгинохайрхан дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүрэг, Баянзүрх дүүрэг/-ийн ажлын байрыг олон нийтэд нээлттэй зарлаж сонгон шалгаруулалтыг зохион байгуулан нийт 12 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн 31 салбарт нөөц бүрдүүлэх сонгон шалгаруулалтын зарыг байгууллагын албан ёсны цахим хаяг lac.gov.mn, legalinfo.mn сайт болон Монголын Хуульчдын холбооны албан ёсны вэб сайтад тавьж олон нийтэд мэдээллээд байна.

Хууль зүйн туслалцааны төвийн нийт албан хаагчдаас 2019 оны ээлжийн амралтын саналыг авч Төвийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/02 тоот тушаалаар албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг баталж тус хуваарийн дагуу ээлжийн амралтыг бүрэн эдлүүлсэн.

3.2 Эдийн засгийн баталгааг хангах ажлын хүрээнд:

Төвийн захирлын 2016 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/10 тушаалаар баталсан Хууль зүйн туслалцааны төвийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

- Ажлын 1-5 хоногийн цалинтай чөлөөг давхардсан тоогоор 36 албан хаагчид,
- Үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээний дагуу үнэлж дүгнэн нийт албан хаагчдад урамшуулал олгосон.
- Хоол, унааны зардлыг 13 албан хаагчид тус тус олгосон байна.

3.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, аятай нөхцөлөөр хангах ажлын хүрээнд:

- Хууль тогтоомжид заасан албаны чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл болон тоног төхөөрөмж, багаж, техник хэрэгслээр нийт албан хаагчийг тухай бүрд нь бүрэн ханган ажиллаж байна.

- Төвийн захирлын 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/04 тоот тушаалаар баталсан чиглэл, хуваарийн дагуу Нийслэлийн 6 дүүргийн 18 улсын өмгөөлөгчид албан үүргээ хэрэгжүүлэхэд нь буюу Цагдан хорих 461-р ангид хоригдож буй тус байгууллагын үйлчлүүлэгчтэй уулзахад албаны унаагаар тогтмол ханган ажиллаж байна.

3.4 Орон сууцны нөхцөлөө сайжруулах, орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд:

- Албан хаагчид цалингийн зээл авах, бусад шаардлагатай тохиолдолд байгууллагаас шаардагдах баримт бичиг, цалингийн тодорхойлолтыг тухай бүрд нь гаргаж өгч хэвшсэн.

- Хууль зүй, дотоод хэргийн салбарын “Албан хаагч бүрт-орон сууц” хөтөлбөрийн хүрээнд байгууллагад ажиллаж буй нийт албан хаагчдын орон сууцны судалгаа болон орон сууцанд хамрагдах албан хаагчдын мэдээллийг ХЗДХЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу тухай бүр нь гарган хүргүүлж байна.

- 2019 онд 1 албан хаагч Цагдаа амгалан хотхонд хамрагдахаар гэрээ байгуулаад байна.

3.5 Албан хаагчдын ажлын орчин нөхцөлийг сайжруулж, тэдний эрүүл мэндийг хамгаалах ажлын хүртээмж, чанарыг дээшлүүлэх ажлын хүрээнд:

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээг зохион байгуулж 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр ТТАХНЭ-ийн урьдчилсан үзлэг, оношилгоонд нийт албан хаагчдыг бүрэн хамруулсан.

Дөрөв. Байгууллагын төсөв, санхүүгийн чиглэлээр:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, тайлагнах, үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж ажилласан бөгөөд Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журам, Хууль зүй, дотоод хэргийн яамны салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг удирдлага болгон ажиллалаа.

2019 оны жилийн эцсийн байдлаар тус төв нь улсын төсвөөс 975,317,100.00 мянган төгрөгийн санхүүжилт авч 975,317,100.00 мянган төгрөгийн зардал гаргаад байна. Үүнээс ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 742,697,500.00 төгрөг, бичиг хэргийн зардалд 10,742,800.00 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 10,030,800.00 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 12,409,000.00 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 4,264,900.00 мянган төгрөг, урсгал засварын зардалд 6,374,100.00 мянган төгрөг, байрны түрээсийн төлбөрт 32,000,000.00 мянган төгрөг, БҮТЭЗ-ийн зардалд 2,136,600.00 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 28,486,200.00 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 9,405,900.00 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардалд 8,396,400.00 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 3,600,000.00 мянган төгрөгийг

зарцуулаад байна.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх үүднээс байгууллагын албан ёсны цахим хуудас www.lac.gov.mn болон шилэн дансны нэгдсэн системд байгууллагын жилийн төсөв, эхний 01 дүгээр сараас 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг тухай бүрд нь байршуулан ажиллаад байна.

Тав. Байгууллагын үйл ажиллагаатай холбогдох бүх төрлийн мэдээллийг олон нийтэд ил тод, ойлгомжтой байдлаар түгээх ажлын хүрээнд:

Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын албан ёсны цахим хуудас болон олон нийтийн сүлжээг хөтлөн мэдээ, мэдээллийг цаг тухайд нь байнга шинэчлэн Хууль зүйн туслалцааны төвийн албан ёсны цахим хуудас www.lac.gov.mn, фэйсбүүк хуудас www.facebook.com/legalaidcenter, твитер хуудас www.twitter.com/LegalAidCenter1-д мэдээ, мэдээлэл, холбогдох хууль тогтоомжийн талаар тогтмол шинэчлэн байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 65 мэдээ мэдээллийг байгууллагын www.lac.gov.mn цахим хаягт тухай бүр оруулсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, хэрэгжүүлсэн арга хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт, байгууллагын 2019 оны батлагдсан төлөвлөгөө, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас www.lac.gov.mn болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Байгууллагын санхүүгийн дараах мэдээллийг цахим хуудас http://lac.gov.mn/?page_id=486 шилэн дансны нэгдсэн системд тухай бүр байршуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Үүнд:
-Тухайн жилийн батлагдсан төсөв, гүйцэтгэл;
-Дараа жилийн төсвийн төсөл;
-Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт;
-Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, урамшуулалд зарцуулсан тайлан;
-Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ;
-Санхүүгийн тайлан;
-Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;
-Аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан;
-Байгууллагын батлагдсан орон тооны өөрчлөлт;
-Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ;
-Улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын улирлын мэдээлэл;
-Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар.

Хүний нөөцийн ил тод байдлыг хэрэгжүүлэх чиглэлээр улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтын зарыг давтагдсан тоогоор 9 удаа байгууллагын албан ёсны цахим хуудсанд http://lac.gov.mn/?cat=11 байрлуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Байгууллагын албан ёсны цахим хуудсыг шинэчлэн 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтанд оруулж иргэд, олон нийтэд зохих мэдээ, мэдээллийг түргэн шуурхай, ойлгомжтой байдлаар өгөх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэж байна.

Зургаа. Эрх зүйн мэдээ мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр зохион байгуулагдсан ажлууд:

6.1 Сургалт, сурталчилгааны чиглэлээр:

Хууль зүйн туслалцааны төвийн 2019 оны сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг 2 дугаар сард баталж, төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг олгох сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Үүнд:

- Улсын өмгөөлөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хийсэн.
  Тухайлбал: Хууль зүйн туслалцааны төвөөс Монголын Хуульчдын холбоотой хамтран 2019 оны 03 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч нарт Хуульчийн үргэлжилсэн багц цаг хангах сургалтыг зохион байгуулан тус төвийн 53 хуульчийг хамруулж 3 кредит цагийг хангуулсан. Мөн Монголын Хуульчдын холбоотой хамтран орон нутгийн салбаруудад албан томилолтоор ажиллахдаа улсын өмгөөлөгчдийг Хуульчдын үргэлжилсэн багц цаг хангах 1 кредит цагийн сургалтад Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Өмнөговь, Дундговь, Төв, Дорноговь, Говьсүмбэр, Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймгуудын салбарын улсын өмгөөлөгчдийг хамруулаад байна.
- Төвийн ажлын алба болон салбарын улсын өмгөөлөгч, түүний туслахуудад Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Б.Тэрбиш “Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдэвт сургалт,
- Архивын ерөнхий газрын сургалтын төвийн сургагч багш Ц.Золжаргал “Баримт бичгийн стандартыг хэрэгжүүлэх нь” “Архивын баримтын хадгалалт хамгаалалт”,
- Төрийн албаны зөвлөлийн референт н.Бундхорол “Төрийн албаны тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт,
- Нийслэлийн МХГ-ын Хөдөлмөр хамгааллын улсын ахлах байцаагч Ш.Хонгорзул “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”, “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сахин мөрдөх”, “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх” сэдэвт сургалт,

- Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн н.Алтанзагас “Гамшигаас хамгаалах тухай хууль, гамшгийн тухай ерөнхий ойлголт, галын аюулгүй байдал” сэдэвт сургалтуудыг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд зохион байгуулж нийт 66 албан хаагч хамрагдсан.
- Мөн Супер ассист ХХК-ны захирал Б.Эрдэнэбаяр Мэдээллийн нэгдсэн сангийн программын практик сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдөр албан хаагчдад зохион байгуулсан.
- Авлигатай тэмцэх газраас 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 3 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нийтийн албан тушаалтныг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, чадавхжуулах замаар авлигаас урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад мэдүүлэг гаргагч 4 албан хаагчийг хамруулсан.
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн талаар сургалтыг Хүний эрхийн үндэсний комиссын Хүний эрхийн боловсрол, сургалт хариуцсан референт Х.Цэцгээ 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Хуульчдын танхимд зохион байгуулж ажлын албаны болон нийслэл дэх салбарын 21 албан хаагч хамрагдсан.
- Хууль сахиулах Их сургуулийн Удирдлагын академийн удирдах албан тушаалтнуудад зориулсан “Стратеги дамжаа” сургалтад 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Төвийн захирал, Захиргааны удирдлагын хэлтсийн дарга нар хамрагдсан.
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгээс Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал баталсан өдөрт зориулж Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Эрхийнхээ төлөө нэгдэцгээе” уриатай “Хүний эрхийн өдөрлөг” арга хэмжээнд ажлын албаны болон нийслэл дэх салбарын нийт 13 албан хаагч хамрагдсан.

<u>6.2 Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр:</u>

Монголын үндэсний олон нийтийн телевизээс бэлтгэн явуулдаг "Эрх зүйн хөтөч" нэвтрүүлгийн ээлжит дугаарыг Дорноговь, Сэлэнгэ аймаг дахь салбарын "Иргэдэд үйлчлэх танхим"-аас бэлтгэн оролцож Хууль зүйн туслалцааны төвийн талаар олон нийтэд сурталчилсан.

Сүхбаатар аймаг дахь салбар нь 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр, 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд орон нутгийн телевизийн “ЭРХ ЗҮЙН ЦАГ” нэвтрүүлгээр иргэдэд хууль эрх зүйн мэдээлэл өгч оролцсон.

Баян-Өлгий аймаг дахь салбар нь Аймгийн Үндэсний радиод Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулиудаар 8 удаа, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн талаар 2 удаа ярилцлага өгч оролцов. Мөн аймгийн «Саян» телевизэд Хүүхдийн хүмүүжил, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Согтууруулах ундааны хүний

эрүүл мэндэд үзүүлэх хор уршигийн талаар болон аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар 7 удаа ярилцлага өгсөн.

Булган аймаг дахь салбар нь Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөрийн хүрээнд иргэдийг хууль, эрх зүйн мэдээллээр хангах зорилгоор 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Гэр бүлийн FM 106.5 радиотой хамтран “Хуулийн хөтөч” шууд нэвтрүүлэгт оролцож салбарын үйл ажиллагааг сурталчилсан.

Түүнчлэн МҮОНРТ-ийн “Иргэдийн эрх зүйн боловсрол” шууд нэвтрүүлэгт 2019 оны 10 дугаар сарын 30–ны өдөр 2 улсын өмгөөлөгч оролцож иргэдийн асуултад хариулж, зөвлөгөө мэдээлэл өгч амжилттай оролцсон..

<u>6.3 Байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах чиглэлээр:</u>

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар дараах ажлыг хийсэн байна.

Үүнд:

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын их танхимд зохион байгуулагдсан арга хэмжээнд тус төвөөс улсын өмгөөлөгч, албан хаагчид оролцож байгууллагын үйл ажиллагааны танилцуулга бүхий 300 гаруй гарын авлага брошурыг иргэдэд тарааж, 135 иргэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

- БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж, амьдрахаар явж буй Монгол Улсын иргэдэд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль болон гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, хууль зүйн мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор долоо хоног бүрийн Мягмар гараг бүр сургалт зохион байгуулж байгаа бөгөөд 27 удаагийн сургалтад 880 иргэн хамрагдсан байна.

- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, салбар байгууллагуудын уялдаа холбоог нэмэгдүүлэх, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх зорилготой Монголын Хуульчдын холбооноос 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан “ХУУЛЬЧДЫН ПРОБОНО ӨДӨР-2019” өдөрлөгт Хууль зүйн туслалцааны төвийн нийслэлийн болон орон нутгийн 31 салбарын улсын өмгөөлөгч нар оролцож, улсын хэмжээнд нийт 1000 гаруй иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

- Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол, Сүхбаатар, Налайх дүүрэг, Булган, Сүхбаатар, Баян-Өлгий, Ховд, Баянхонгор, Дундговь, Сэлэнгэ, Өвөрхангай, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Увс аймаг дахь салбарууд 2019 оны 2 дугаар улирлын байдлаар 24 удаагийн сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулж 1529 иргэнд Төлбөрийн чадваргүй яллагдагчдад үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль салбарын үйл ажиллагааны талаар сургалт сурталчилгааг хийсэн.

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн салбарын агентлаг, байгууллагуудын “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулагдаж өдөрлөгийн хүрээнд Хууль зүйн туслалцааны төвийн нийслэлийн салбарын улсын өмгөөлөгчид идэвхитэй оролцож нийт 221 иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгч, ажлын албаны болон нийслэлийн салбарын бусад албан хаагчид байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдэд сурталчилан таниулж, холбогдох бусад мэдээ мэдээллийг өгч ажилласан.

Долоо. Бусад ажил:

“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын төслөөр хэрэгжиж буй “Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд төвийн болон салбарын статистик тоон мэдээ болон бусад мэдээллийг агуулсан “Мэдээллийн нэгдсэн сан, веб-д суурилсан програм хангамж” хөгжүүлэх ажлыг Супер ассист системс ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж хүлээн авч ашиглалтанд оруулсан.

Иргэдэд эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэд шаардлагатай үедээ оршин суугаа газраасаа хууль зүйн туслалцаа авах нөхцөл боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд 2018 онд нийслэлийн Сүхбаатар дүүрэг, Сэлэнгэ аймаг дахь салбарт Иргэдэд үйлчлэх танхимыг нээсэн бол 2019 онд Дорноговь аймаг дахь салбарт “Иргэдэд үйлчлэх танхим”-ыг 04 дүгээр сарын 05-ны өдөр нээлтийн арга хэмжээг зохион байгуулж иргэдэд цаг хугацаа алдалгүй түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Цаашид Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн салбарт “Иргэдэд үйлчлэх танхим”-ыг нээн ажиллуулахаар өрөө тасалгааг тухайн орон нутгийн удирдлагаар шийдвэрлүүлж бэлтгэл ажлыг хангахаар төлөвлөсөн.

Хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх энгийн тарифтай 7000-1982 дугаартай утсыг Сүхбаатар дүүрэг дэх салбарын “Иргэдэд үйлчлэх танхим”-д ажиллуулж улсын өмгөөлөгчид утсаар хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгдөг үйлчилгээ 2018 оноос эхлэн үзүүлсэн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын байдлаар нийт 562 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

Мөн хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх 7000-1982 дугаарын утсыг “CALLPRO” үйлчилгээнд холбох ажлыг 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр эхлүүлж Сүхбаатар, Сонгинохайрхан, Налайх дүүрэг болон Булган, Говь-Алтай, Завхан аймаг

дахь ахлах улсын өмгөөлөгчийн гар утсанд шууд холбогдон иргэд хууль эрх зүйн зөвлөгөө мэдээллийг ажлын цагаар өгч байна. Цаашид 46 улсын өмгөөлөгчийн утсанд холбох ажлыг судалж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагуудын төв аппаратын ажилтан, албан хаагчдын дунд уламжлал болгон зохион явуулдаг спортын тэмцээнд дөрөвдүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд албан хаагчдад 4 төрөлт тэмцээнд идэвхи санаачлагатай оролцсон.

2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан “Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа агентлаг, байгуулагын гадаад харилцаа хариуцсан нэгжийн дарга, албан хаагчдын зөвлөлдөх уулзалт”-нд 1 албан хаагч оролцов.

- Мөн 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний чуулга”-нд 1 албан хаагч,
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Нээлттэй нийгэм форумтай хамтран зохион байгуулдаг “Хүний эрхийн олон нийтийн лекц”-д 2 удаа 4 албан хаагч,
- 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан Хууль зүй, дотоод хэргийн салбарын “Бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны анхдугаар зөвлөгөө”-нд 1 албан хаагч тус тус хамрагдсан байна.

---oOo---